



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/462


Ховд

Санхүүжилт олгох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 67 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хэрэгцээний мах бэлтгэн нийлүүлэхээр шууд гэрээ байгуулан ажиллаж байгаа “Хан жаргалант Ховд” хоршоо, амьд хонь нийлүүлэхээр ажиллаж байгаа “Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт гэрээний дагуу санхүүжүүлэх тус бүр 100 000 000 төгрөг /нэг зуун сая/-ийг олгосугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 200.000.000 төгрөг /хоёр зуун сая/-ийг аймгийн Техник хяналтын зардлын хангамжаас буцаан төвлөрүүлэх нөхцөлтэйгээр олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ